

Түүх соёл, хэл бичиг судалын  
ТОД НОМЫН ГЭРЭЛ ТӨВ

---

BIBLIOTHECA OIRATICA

LXXVII

# ТОД ҮСЭГ - 370

(Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл)

Эмхэтгэж, эрхлэн хэвлүүлсэн:  
На.Сүхбаатар

Цувралын редактор: Б.Түвшинтөгс  
Ботийн редактор: Х.Бямбажав

УЛААНБААТАР  
2018

ННА 94  
ДАА 080  
Т-45

Эл бүтээлийг  
“Тод үсэг - ХХI зуун”  
төслийн санхүүжилтээр хэвлэн нийтлэв.

Тус бүтээлд 2018 оны 06 сарын 22-23 ид Улаанбаатар хотноо хуралдсан тод үсэг зохиосны 370 жилийн ойд зориулсан “Тод үсэг – 370” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцэн илтгэлүүдийг эмхэтгэн оруулсан болно.

**ТОД ҮСЭГ - 370**  
**(Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл)**

Эмхэтгэж,  
эрхлэн хэвлүүлсэн: На.Сүхбаатар  
Цувралын редактор: Б.Түвшинтөгс  
Ботийн редактор: Х.Бямбажав  
Хэвлэлийн эх бэлтгэсэн: П.Номинцэцэг  
Хавтасны дизайнер: Б.Эрдэнэбулаган

Цаасны хэмжээ: 70x100/12.  
Хэвлэлийн хуудас: 16.3 х.х  
УБ., "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэр. 2018, 196 х. ISBN 978-99978-761-2-6

---

Copyright © Тод номын гэрэл төв ТББ, 2018

© Соёмбо принтинг ХХК (Хавтасны загвар), 2018  
ISBN 978-99978-761-2-6

Түүх  
зорилгынх  
сурвалжий  
туурвилий  
ratica (Ойр  
55, 57, 59,  
Үүнээс га  
үсэг зохи  
хурал, 20  
80 жилий  
Мөн “Тод  
дурсгал, 3  
гадаад дот

Манай  
судлалтай  
“Тод бичи  
шинжилгэ  
байгуулла  
судлаачид  
сургуулий  
төлөөлөл  
идэвхжүү

“Тод ү  
дэвшүүлс  
хамгаала  
түүний су  
үсэг судла  
судлаач эр

Хурль  
Ч.Сундуй  
үсгийн тү  
аймгийн  
эрмэлзсэн  
шавилж б  
сургажээ.  
төлөвшил  
сургалтын

## МОНГОЛ УЛСЫН АЛТАЙ УРИАНХАЙЧУУДЫН ТОД ҮСГИЙН ХЭРЭГЛЭЭ (Аман түүхийн судалгаа)

ОНДРЕЙ Срба / Ondřej Srba  
(Чех улсын Карлын их сургуулийн багш, доктор)<sup>1</sup>.

### Англи хэлний гарчиг:

Todo bičiq among Altai Urianhai in Mongolia (Oral histories)

### Англи хэлний хураангуй:

*During Qing period, todo bičiq (clear script) was used as the official administrative script in banners belonging to military governors in Ghulja and Tarbagatai, but in the area subordinated to Khovd ambanate Mongolian script was in use. Knowledge of Mongolian script was also required from Altai Urianhai governors (amban and bügüde-yin daruy-a). The use of todo bičiq was limited there to the private religious sphere. A research of oral history among Altai Urianhai in Xinjiang proved that there once existed a similar tradition of non-monastic religious specialists hara bagši as attested among Ööleds in the upper reaches of Ili river. But among Altai Urianhai in Mongolia, the term hara bagši is scarcely known and it seems that no villager (except a few university graduates) is now fluent in todo bičiq.*

This contribution based on oral historical research would like to reconstruct images of three outstanding bearers of the clear script literary tradition among Altai Urianhai in 20th century. In the Left Wing Amban's Banner, Menddavaa has been described as a hereditary *hara bagši* who came to Mongolia (present Altai sum, Bayan-Ölgii) from Xinjiang during 1930s migration. In the Right Wing Amban's Banner (presently Bulgan sum, Bayan-Ölgii), T. Togtoh and her daughter D. Muuža represent female lay devotees (*usanz*) who practised regular reading of the most popular clear script sutras as the most noticeable act of their praxis pietatis. A dependent of the same banner, recently citizen of Mönkhairhan sum, Hovd aimag, S. Naadgai, personifies the intellectual legacy of the old banner nobility surviving until the end of 20th century.

### Өмнөх үг

Алтай Urianhaychuud Зүүнгарын үед шарын шашинд ороод бусад Ойрадын адиллаар Зая бандидагийн тод үсгийн судрын орчуулгын уламжлалыг хэрэглэж

<sup>1</sup> Research in Mongolia and publication of this article was possible thanks to the support of the Czech Science Foundation (Grant GA15-12215S)

байжээ. Шинжааны Тэкс голын урсгал дагуу Өөлдийн дунд өнөө хүртэл үзламжилж ирсэн тод үсгийн ном судар унших “хар багш” нарын зан үйл (энэ сэдвээр судалсан голдуу Erdemtü Mingyad 2014) Алтай Урианхайчуудын дунд бас түгээмэл байсныг Шинжаан дахь Алтай Урианхай болон Монгол улс дахь Алтай Урианхайн зарим сумуудад хийсэн аман түүхийн судалгаа батлаж байна. Алтай Урианхайн долоон хошуу Манж Чингийн үед Ховдын амбандаа харьялагдаж байсан тул захиргааны хэрэгт монгол бичиг хэрэглэж, тод үсгийн хэрэглээ шашин болон хувийн хэрэгцээнд хязгаарлагддаг байв. 20-дугаар зууны хоёрдугаар хагаст Алтай Урианхайчуудын дунд тод үсгээр ном судар уншиж дэлгэрүүлж байсан сүүлчийн цөөхөн хүнийг төлөөлүүлж гурван хүний намтрыг аман түүхийн дагуу өгүүлнэ. Нэгдүгээр нь, Баян-Өлгий аймгийн Чулуукаан Батнасан (1884–1960). Итийн Монголхүрээ болон Баруун Алтайд ном нээх зан үйлд голдуу эрэгтэй хүмүүс оролцож байсан бол, Булган болон Мөнххайрхан сумын нутагт тод үсэгтэй эмэгтэй хүн цөөнгүй байсныг аман түүх дурсан ярьдаг байна. Нэг нь, Баян-Өлгий аймгийн Булган сумын нутагт аж төрж байсан Түрүүний Тогтох (1889–1963) болон түүний охин Дамдины Муужаа (1909–1992). Нөгөө нь, Ховд аймгийн Мөнххайрхан сумын иргэн агсан Санжийн Наадгай.

### **Алтай Урианхайн Зүүн амбаны хошууны Т. Мэнддаваа хар багш**

Баруун Алтайд Урианхай хар багш нар хөлгөн судар нээх, өвчтэй хүнийг эмнэх домнохын хажуугаар гээгдсэн буюу хулгайд алдагдсан мал, эд зүйлийг очир гүйлгэх, сум гүйлгэх аргаар эрэн сурвалжлах зэрэг зан үйлийг Илийн хар багш нарын нэгэн адилаар гүйцэтгэдэг байв. Хандгайтад сүүлийн хар багш нарын нэр бол Аишан, Гомпил, Жахаан, Папаан; Чингэл сианд Шийрэв, Өчиг, Чойсүрэн. Олон хар багш бүлэглэн цугларч хөлгөн судруудыг хамтран нээж унших зан үйл үндсэндээ 1980-аад оны үед тасарсан гэнэ.<sup>2</sup>

Чулуукаа, Мэнддаваа ах дүү хоёр 1930-аад оны эхээр Баруун Алтайгаас давж ирээд Сагсайн голд суурьшин тогтсон. 1940 онд Баруун Алтайгаас давж ирэгсэд гэдэргээ нүүх болсонд Чулуукаан эхнэр шинэхэн жирэмсэн болсон болохоор яваагүй. Гэвч Дүгэржaa гэдэг айл нүүгээд үлдээсэн тэмээг нь Чулуукаа өөртөө хадгалснаас сэжиглэгдэж баригдаад Ховдын широнд буудуулсан гэнэ. Чулуукааг хэлмэгдсэнээс болоод түүний ах Мэнддавааг 3 жил Увсын Улаангом орчмын газарт цөллөгөнд явуулсан билээ. Баян-Өлгийд харьж ирээд дүү Чулуукаан өнчирсөн хөвүүн Батнасаныг асарч өсгөсөн байна (голдуу 15–18 настай үед нь хамт байсан). 1960 онд 77 буюу 78 насандаа бурхан болоод Батнасан гэрийг нь, гал голомтыг нь залгамжилж авав.

Чулуукаа, Мэнддаваа хоёрын эцгийн нэр Төвшин, Төвшиний ах Жилкэр суман занги тушаалтай байв. Тэр бээр занги тушаалаа эцэг Мидэг, өвөг Майдаг, элэнц эцэг Маам нараас залгамжилж авав.

<sup>2</sup> БНХАУ-ын Шинжаан УӨЗО-ны Алтай хотын Хандгайт тосгон, Банди өвгөн (2013.8.30.) болон Чингэл сианы Батцаагаан/Бэкээн (2013 он) нарын ярьсан аман түүхээс.

Батнасан гуайн өгүүлснээр Мэнддаваа авга ах нь залуу бага насандаа сахилгагүй бүтэлгүйтэж, архи ууж, үзэгдсэн хүнтэйгээ яриа хөөрөө үзэгддэг, Алтайн Шар сүмийн лам хуврагтай хэрэлдэж цохилдсоноос болоод тэнд 45 хоногийн хугацаагаар шоронд баригдсан гэнэ. Ялаа эдэлж дуусаад өвөл хаврын өлсгөлөн цагт ганц биеэрээ явган гэртээ харих замдаа нэг хадны унгид үхэж дөхөөд тэгээд өглөө босож аваад явч байхад толгой дээр нь юм пад гээд дээдэс огторгуйгаас юм унаж ирлээ. Сөхөж үзвэл нэгэн судар бөлгөө. Судраа өвөрлөж явж байтал замд нь ном мэддэг нэгэн хар багш таарсанд санамсаргүй олсон судрын учрыг асуувал хар багш тод ном хэмээн айлдаж Мэнддавааг азтай хүн хэмээн тод номыг заахаар болов. Хоёр гурван сар тод ном сураад Мэнддаваа хар багш болоод насаараа нутаг усандаа тус болж явав.

Батнасан гуайн ойлгосноор, хар багш бол өөрөө эрдэм номыг сураад биечлэн сурсан хүнийг хар багш гэж хэлнэ. *Хар багши бол хүүхдийн ба эмэгтэйчүүдийн өвчин тод номоор мэддэг*. Мэнддаваад тэнгэрээс бууж ирсэн ном “Көк хуцын дом” гэдэг ном байсан гэнэ. Баруун Алтайд байхдаа Мэнддаваа олон номтой байсан боловч Алтай давж ирэхдээ зөвхөн “Хөх хуцын дом” хийгээд “Мэргэн самса” хэмээх хоёр судраа авчирсан гэв. Түүнийг бурхан болсны хойно ном судрыг нь түүний хүүр цогцтой хамт уул хаданд тавьчихсан бололтой.

30-аад оны сүүлээр Т. Чулгуукаа, Б. Орос, Хишигт гурав Казахын нүүдэл, дээрмийг эсэргүүцэж Хуримтын Зэл харгай гэдэг газарт Төлөгөтэйд баригдаж, шөнө гол усаар оргood зугтсан гэнэ. Гэвч Чулгуукаа удахгүй эсэргүү болон сэжиглэгдэж Онгорхой нуурын орчмоор нуугдаж явтал баригдаад Ховдын шоронд орж хэлмэгдсэн гэнэ.

1940 онд Мэнддавааг Увс аймаг руу нүүлгэсэн үед түүний номын мэдлэг чадвар түүнд болон түүний гэр бүл, хот айлд хэрхэн тус нэмэр болсон тухай Батнасан гуай дараах үлгэр хэлэв. Хавар Увсад нүүгээд хүрснийхээ нэг хоёр сарын дараа чөдөрлөж аргамжилсан хоёр гурван морийг нь Өлзийт гэдэг айлын морьтой хамт хулгайч аваад явж одсон. Зуны хур бороо ихтэй цаг үе байсан гэнэ. Өглөө босоод адuu нь алга болсныг мэдээд Мэнддаваа тод судраа уншаад, сан тавиад, хөх зурхай зураад:

*... араас нь тэр зүг рүү яв гээж тэр зурхай дээр буусан байна л даа. Их тохой арал тийм газар, бураатай. Их бороо орсон, гол байсан, тэр хоёрыг [= тэр хоёр хулгайчийг] ном уншаад усыг оргуулчихсан. Тэгээд усаар гатлааж чадахгүй, дотор [арал дээр] сууж байсан, хоёр хулгайч. [Мэнддаваа] адуугаа аваад, голын наад талд авсан. [Хоёр хулгайч:] “Чи муу тэнээж ирсэн Урианхай өнөөдөр адуугаа аваад яваарай. Маргааш чамайг дахиад чадна.” - “Чи чадах юм уу, би чадах юм уу үзье.” Тэр гэртээ ирээд зурхай зураад тод номоор уншаад хаячихсан байна. Гурван дөрвөн хоноод байж байсан нэг өдөр тэгсэн чинь үд өнгөрч байхад баахан хүн ирж байгаа, тэмээний ачаатай гэр ачсан. Тэгсэн чинь өчигдрийн ... нөгөө нэг хоёр хүн буулгаад, хоёр гэр бариад хоёр хулгайч хоёулаа эрүү гарсан. ... Манай*

насандаа узэгддэг, тэнд 45 л хаврын гид үхэж эд дээдэс өвөрлөж үй олсон азтай хүн даваа хард биечлэн үйчүүдийн төк хуцын номтой “Мэргэн ойно ном нүүдэл, баригдаж, түү болон д Ховдын ын мэдлэг сон тухай нэг хоёр дэг айлын яисан гэнэ. шаад, сан Их тохой = тэр хоёр үй, дотор олын наад эр адуугаа чадах юм сан байна. хад баахан . нөгөө нэг ... Манай хөгшинд: “Та энэ хоёр [хулгайч] хүүхдийг эрүүг нь оруулж өгөөч” гүйсан байна. “Манай нутагт нэг сайн умалга татдаг бөө байсан. Бөө бөөлүүлээд: “Тэр адуу авсан хүн чинь юм мэддэг хүн байна тэр хулгайчид хэлсэн. “Би яаж ч чадахгүй, болохгүй. Та нар тэр хүнд оч. Өөрөөр нь янзлуул.” Тэгээд нөгөөдөх тэр өдөр хоноод өглөөд нь аарцаа тавиад хүргээд тэгээд нөгөө хоёр хүн гарч – [нөгөө хулгайч] мөн [байна. Мэнддаваа дотроо бодож:] “Одоо яах вэ? [Хулгайч ч гэсэн] хүн байна.” [Тэгээд] “Би ингээд газрын холоос бараг Сагсайн эхнээс нүүж ирсэн, одоо ингээд Дөрвөдийн нутагт цөлөгдсөн хүн ээ. Одоо ингээд ядарч явахдаа надыг [=намайг] басамжлаад, хулгай хийгээд, адууг минь аваад би ингэлээ.” Номоо уншаад, нөгөө хоёрыг ном уншаад сан тавьчихаад ганц ганц ингээхихсэн, тэр хоёрын эрүү хуучин хэвэнд орчихсон байна. Тэгээд нөгөө хоёулаа нүүгээд явсан гэдрэг нутгуураа [нутаг уруугаа]. Чулуунбаатарын ээж ярьдаг байсан: “Ая, ая, чадалтай хүн билээ. Тэрнээс хойши мал хулгай хийх байтугай ухэр адуу энэ тэр тавьж гэхүүл [Дөрвөдүүд бидэнд] өөрсдөө түүж ирж өгдөг, гурван жил бид нар жаргаж байсан.” Тэр эмгэн тэгж ярьж байсан: “Ая, ая, бас сайхан хүн билээ. Бид нар тэнд цөллөгөнδ [=цөллөгт] биш, адаг суулд баяжсаад ирсэн. Танай өвөг бүр ч дөчөөд адуутай болоод, хоёр гурван зуугаад хонь ямаатай болоод, сарлаг үхэр хорин хэдэн үхэртэй наашаа нүүж ирж байсан. Тэр Дөрвөдүүд бүр шүтэж байсан. Хонь мал хүртэл айлын залуучууд хонь малыг нь хариулж байсан. Нэлээн чадалтай, номтой, сайн мэддэг, сайн тайлбарлаж байсан хүн.” [Надад бас:] “Энэ Хөх хуцын домын домчи заавал сур” [гээж хэлдэг байжээ].<sup>3</sup>

Мэнддаваагийн эцсийн цаг мөчийн тухай Батнасан гуай бас ер бусын мэт сонсогдох мөртлөө түүний мэргэн чадлыг гэрчлэх нэгэн мэдээлэл өгөв.

1960 оны 5 сард Алтай сумын Рашиантаас явж Сагсай гол уруудаж гэртээ харих замдаа гэнэт мориноос унааж нас барахынхаа өмнө төрөл егүүтгэх цаг нь болсныг угтан айлдаж байв гэнэ:

Дараачийн нэг айлд ирээд цай уугаад энэ тэр. “За, миний хугацаа болсон. Шулмын хаанаас хоёр цагийн чөлөө гүйсан. Би одоо явах цаг боллоо. Болбол гэртээ хүрье. Хоёр цагийн чөлөө авахууллаа” [гээж] тэр гэрийн эзэнд хэллээ: “Баяртай, одоо дахиад ирэхгүй.” Тэгээд одоо Зостын тас хэсэг тэндээр завод байсан, заводын эхээр ирээд нэг айлд ... морин дээрээс буугаад цай тавагтай цайнаас амсчихаад яг тэр заводын захаар гараад гурван зуу, дөрвөн зуу метр яваад – гэрийн эзэн хамт явсан байхгүй юу – мориноос унаад: чөлөө нь дуусчихаж. Чойзун гэж лам байж, [түүнд] үзүүлээд энэ хүнийг гэртээ оруулж болохгүй. Хээр тэр хүүрийг нь тэр чигтэй нь тавь, гэрт оруулалгүй. ...

[дахиад ярихаар:] Ингээд сууж байгаад: “За, би тэр шулмын хаанаас хоёр цагийн чөлөө гүйж авсан” гэж яриад. Тэгээд нэг газар Рашиантаас яваад Зост ирээд хоёр цаг нь дуусаад мориноос өнхрөөд өнгөрсөн. Айлын гэрт ингэж сууж байгаад: “За, миний хугацаа дууссан, боллоо, дээдсээс дуудлага ирлээ. Би одоо

<sup>3</sup> Баян-Өлгийн Алтай сумын иргэн Чулуукаан Батнасаас 2017 оны 8 сард сурвалжилсан аман түүхийн ярианаас.

явнаа. Одоо ухэх цаг болсон, хоёр цагийн чөлөө авахууллаа. Тэгээд Рашиаатаас яваад Зост ирээд хоёр цаг нь дуусаад мориноос унаад ...”<sup>4</sup>

Батнасаныг гэр бүл болоход Мэнддаваа авга ах нь түүнийг олон хүүтэй болно гэсэн бэлгэдэн зөгнөж гал голомтоо залгамжуулсан гэнэ.

### **Алтай Урианхайн Баруун Амбаны (Дархан бэйсийн) хошууны нутаг дахь 20-дугаар зууны тод үсгийн хэрэглээний уламжлал, түүний дурсгал**

Алтай Урианхайн Баруун амбаны хошуу буюу Дархан гүний хошууны нутагт 20-р зууны үед тод үсэг мэддэг цөөхөн хэдэн эрэгтэй хүн байсан ч (Цогтын Содвалам, Жамиадай, Чойсүрэнгийн Риймэд/Эрээмэд, Банзарын Рагва), тус газрын аман түүхэнд юуны өмнө гурван эмэгтэй хүн тод үсэг мэддэгээрээ олон нийтэд алдаршсан болно.<sup>5</sup>

**Түрүүний Тогтох** (1963 онд 76 насандаа таалал төгсөв), хуучнаараа Баруун амбаны хошууны Мянгад сум, шашны хэлмэгдлээс урьд усанз (убсанз, са. *ir-āsikā*) сахил хүртээд тод үсгийн ном уншдаг болов. Тод үсгийн мэдлэгээ өөрийн төрсөн охин, **Дамдины Муужаа** (?1909–1992)-д өвлүүлэн заав. Муужаа албан ёсоор усанз сахил хүртэх боломжгүй үед амьдарсан боловч өндөр насандаа ээжийнхээ ёсоор усанз сахилтны ёс дүрмийг мөрдөн сахих болжээ. Сарын 15, 30-нд мацаг барьж Таслагч очир судрыг нээх заншилтай байв. Тогтох, Муужаа хоёр тод үсгийн ном хуулж босгож байсан тухай мэдээлэл байхгүй. “Дорж Зодов” судар уншихдаа бичгийн дуудлагаар уншдаг байсан гэдгийг Муужаагийн хүү М. Чулуун-Очир гуай дурдав (жишээ нь: *tegünčinen bolugsan* “түүнчлэн болсон”, са. *Tathāgata*). Номын уншлагын дараа Муужаа маань хөгжөөж дуулдаг байв. Хүүхдүүдээ бас “Таслагч очир” судрын ач тусын тухай үлгэрийг ярьдаг байв. Нэгэн үлгэрийн жишээнээс энд эш татья:

*ter angčin kün baisan baigaam, ter nöggöö [doržzodoviig] bögsdöö hürgüülsen kün, nügel ih kiideg, kün alna, ter ang alna ... [Анчин хүн нэг удаа хөдөө хээр явж байтал Доржзодов судрыг олж аваад хадгалсан байна.] ühdeg cag bolaad, dal, jar dal garaad, odo bi ühdeg cag bollaa. ter nomoo bi ter joohon kühed baihdaan, zaluu baihdaan, ter nom iim nom olj avsan, iim coohor yum olj avsan, odo ci ter nomiig, odo ühdeg cag bolaad minii bögsd hürgeed ög gesen baina, ter odo geriinhen, kühed tüühded gesen baina, ter nomiig čini bögsdee hürgüülčeed, teged öngörsön baina, bögsdöö hürgüülčeed, ter odo nöggöö hün čini ühlee, nomon haandaa očištee očihlaagaar, künée töröld orohgüi, eniig bol odo očirt tamd hii. maš odo ayuultai nügel hiisen kün, eniig bol hünii töröld oruulahgüi geed, očir tamd hiigeed nöggöökö nomon haan, hoyor yuu bolholaagaar očir tamruu avaačaad hiihlee-*

<sup>4</sup> Баян-Өлгий аймгийн Алтай сумын иргэн Чулуукаан Батнасаас 2014 оны 6 сар болон 2017 оны 8 сард сурвалжилсан аман түүхийн ярианаас.

<sup>5</sup> Тод үсгийн Дорж зодов уншдаг мэргэн самганы дүр Алтай Урианхайн аман үлгэрт ч оров. Тухайлбал Б. Пунцагдоржийн тэмдэглэсэн *Алтууж мэргэн*-д: “Хүү даахьтай бор дааганаасаа буугаад гэрт орвол бас нэг самган Доржзодов айлдаж суужээ. Хүүхэд урьд нь очиж гурав мөргөж, адис хүртээд доод талд нь очиж суув. Самган судраа айлдаж төгөсгөн хойморт залаад Ургаш харж сангaa тавиад хойш эргэж дээжээ тавиад Гадаа гарч зулаг өргөчихөөд Бумбан улаан домботой цайнаас аягалж хүүд өгөв” (Пунцагдорж 1990, 33).

*geer nögök hūnii čeej ni oraad bögs ni ordaggui. gatsan – gatšihsan – dakaad nomon haandaa irj asiuudgiim gene yerdee ene kūnee očir tamruu oruulah gesen čini nögök čeej oraad bögsi orolgüi ter ni yamar ucirtai gej tegeed odoor ter ... bas ter kūnees nögök nomon haan asuudiimbaina l, či yaagaad ter orohgüi, bi ter bagdaa tegj yovj yovahdaa nige tiim coohor nom šingge coohor yum olj avsan, ühehdeereen bögsdöö kürgečihsen, tegeed ter nomiin kūčinteiger tūñees bolaad ter kün tegeed künii töröl olson tegeed tiim ucirtai nom unšdag baisiim, ter maši ih tūñhtei ter taslagč očir, taslagč očir gej doržodov, manai mongoliin ali hüreend dacand baigaa baih ...<sup>6</sup>*

Алтай Чингэлд төрсөн, залуу идэр насаа өнөөгийн Баян-Өлгий аймгийн Булган сумын нутаг, өндөр насаа Ховд аймгийн Мөнххайрхан суманд өнгөрүүлсэн нэгэн эрхэм ахмад настан **Санжийн Наадгай** гэдэг байв. Тэр бээр 1903 оны үед (туулай жил) Баруун амбаны хошууны захирагч Санж гэдэг хүний хоёрдугаар хүүхэд болж төрөв. Санж захирагчийн тухай архивын ч, аман түүхийн ч илүү мэдээлэл олдсонгүй. Санж захирагч Оорцог сумын Түнкэн/Төнхөн элкэний Ах арваны хүн гэнэ. Санж захирагчийг Булганы Гүртийн амны Өнчин чиргаан дэвсэгт оршуулсан бөгөөд оршуулсан газрын шинж нь тохирсонгүй болохоор эрэгтэй хөвүүдээс нь хүүхэд бараг гараагүй гэдэг.<sup>7</sup>

Нaaадгай тод үсгийг залуу насандаа ааваасаа бас нэг эмэгтэй дүүгийнхээ хамт сурсан. Номд авьяастай болсноо тэр бээр өөрийгөө зул сарын хорин таванд төрснөөрөө тайлбарладаг байв. Наадгай самган өвөг дээдсээсээ уламжилж ирсэн тод үсгийн ном судрыг хадгалж, уншдаг байсны зэрэгцээгээр 70, 80, 90-өөд оны үед бас өөрийн гараар олон зүйлийн богино судрыг хуулан босгож байсан. Түүний уламжилсан хуучин судар болон түүний өөрийн гараар босгосон судрыг дараа нь түүний хүү Магсар хийгээд түүний гэр бүл залгамжилж маш нандигнан шүтэж хадгалсаар байна.

Өндөр насандаа Наадгай самган хэдэн удаа эрдэмтэн судлаачтай уулзсан бөгөөд үүний тухай эрдэм шинжилгээний бүтээлүүдэд нэг бус удаа тэмдэглэсэн байдаг. 1978 онд БНЧУ-ын Карлын Их Сургуулийн багш, профессор Ярослав Вацек, профессор Ж. Лувсандоржийн хамтаар Монголын баруун аймгуудаар нутгийн аялгууны хээрийн судалгааны ажлаар явсан үед Мөнххайрхан сумын төвд ирж нутгийн захираганы ажилтнууд тэдэнд өндөр настай хүмүүсийг уулзуулдаг байв. Бусдын дунд бас С. Наадгайг ирүүлсэнд багш нар түүний толгой холбож шүлэглэсэн хариуд ихэд гайхав:

Удалгүй тэр багш нэг хөгжөөнтэй эмгэнийг дагуулаад ирэв. Нэрийн нь Наадгай гэнэ. “За эмгээ минь та малын дэргэд өссөн хүн байна. Малын тухай ярьж өгөөч. Та багадаа хонь хариулж, үнээ сааж байсан биз дээ?” гэж би яриа Үүсгэх санаатай асуув.

<sup>6</sup> Муужаагийн хүү, Майдарын Чулун-Очирын ярьсан аман түүхийн ярианаас (Баян-Өлгий аймгийн Булган сумын Улаанхус баг, 2012.5.14.).

<sup>7</sup> Баян-Өлгий аймгийн Булган сумын Тавуузын Цэцэгмаагийн ярьсан аман түүхийн мэдээгээр 2018.05.18.

Эмгээ: “би тэр мал зал хариулах, үнээ мүнээ саахыг мэдэхгүй өссөн хөөн! Бага залуудаа морины сайныг унаж, торгоны сайныг өмсөж, бишгүүр лимбэ татаж, бичиг дэктэр үзэж явлаа” гээд шулэглэж байна. Би их гайхаж, ялангуяа ямар бичиг үзэж байсны нь асуувал:

“Энэ нутгийн хошуу ноёны охин билээ би.  
*Мал гэвэл мэдэхгүй,*  
*Мах гэвэл иднэ.*  
*Ажил гэвэл мэдэхгүй,*  
*Архи гэвэл ууна.*  
*Худам гэвэл мэдэхгүй*  
*Тод гэвэл үзэглэнэ”* гээд дахиад л шулэглэж гарав.<sup>8</sup>

1988 онд Наадгай ШУА-ийн судлаач И. Лхагвасүрэнд их хэмжээний угсаатны зүйн мэдээллийг хангаж өгөв.<sup>9</sup> Ж. Цолоо 1971 оны судалгааныхаа үндсэн дээр “Урианхай түмний бичгийн соёл” бүлэгт (*Урианхайн өв соёл* 2008: 424-427) С. Наадгайн мэдээлсэн тод бичгийн цагаан толгойн дуудлагыг (үсэг болон үсгийн үндсэн зурлагын уламжлалт нэр томьёо) танилцуулж бичгийн сурвалж дотор гардаг цагаан толгойн дуудлагатай харьцуулав.<sup>10</sup> Наадгайн хүү Магсар, бэр Поолуугийн Ноосгой нарын хэлснээр Наадгай тод бичгийг бага насандаа эцгээсээ сураад идэр насандаа хэрэглэлгүй орхиж, нас өтөлсөн хойно тод бичгийн мэдлэг хэрэглээгээ дахиад сэргээж ном уншдаг, хуулан олшруулах, хүн амьтанд тараах болов.

### C. Наадгайн гар бичмэлийн өв

Намайг Мөнххайрхан суманд очиход Поолуугийн Ноосгой хадам ээжийнхээ өвлүүлсэн ном судрыг үзүүлж гэрэл зургийг нь авахуулав. Тус цуглуулга хоёр хэсгээс бүрдэж байна: хуучин судар болон Наадгайн бүтээсэн судар. Хуучин судар оросын гар аргаар үйлдвэрлэсэн цаас болон 19-р зуун ба 20-р зууны эхний үеийн оросын механикжуулсан үйлдвэрийн цаасан дээр харьцангуй хичээнгүй тигээр бичсэн бол Наадгайн босгосон судар орчин үеийн, ихэвчлэн хатуу, цав цагаан гялгар цаасан дээр мэргэжлийн бичээч бус хүний тигээр бичсэн байdag болохоор энэ хоёр төрлийн судрыг ялгахад амархан. Судрын жагсаалт дараах мэт болно:

#### C. Наадгайн босгосон судар

1. *itegel orošibai*, 5 хуудас
2. *arban burxani z[ajrlıq orošibai*. Нугалбар хэлбэртэй ном, 19 нүүр.
3. *sukew[a]diyin iröl orošibui*, 6 хуудас

<sup>8</sup> Энд эшилсэн дуртгалыг Ж. Лувсандорж С. Наадгайтай уулзсаныхаа тухай монгол хэл сурх цувралын хоёрдугаар ботид оруулав (Luvsandordž – Vacek 1990, 137). Ярослав Вацек баруун аймгуудаар аялсныхаа тухай *Nové Orient* гэдэг Чехийн дорно дахини судлалын сэтгүүлд тэмдэглэл нийтлүүлэв (Vacek 1980).

<sup>9</sup> Түүний нийтэлсэн тэмдэглэл: МУЗСЭХ 2011, 32–33, 40, 64.

<sup>10</sup> Цолоо – Мөнхцэцэг 2008, 424–427.

4. zoürdüyin sonosod toniloqci sudur orošiibu, 14 хуудас
5. *tamu ebdeküxouri kemekü altan usun xutuyan oršiboi*; хуудас 1v: *xamuq kile[n] ce nam[an]čilxu sudur*: Эхлэл: *enedkegiyin kele[n]dü nā mā sarwa ta thā ya ta: puddha širi: töbödiyin kelen-dü: sdiqba tamjid bšaqbai mdo: mongyoliyin kelen-dü: xamuq kile[n]ce nam[an]čilxu sudur arban züg yurban cagiyin xamuq burxan bodhi satwa nar-tu mörgümüi::* Төгсгөл: [11v] *kilince namančilxu altan usun xutuyan tamun ebtekü xouri kemekü dousubai:: kili[n]ce nam[an]čilxu altan usun xutuya ööni kir-ügei burxan-ni šajindu oroqson:: dges[l]ong banoroi durduq-san-du keteqtü [!] amitan-nomiyin öödün-dü oroxuyin tula kelen töböd-ece rab byampa corji kemekü orčiul[u]qsan ene büye-yer [!] arban xar [!] nüüliyin uq-ece tebčiji:: arban cayan buyan noyoud saitur tögüsün: arban barim[a]d bügüdi dousun üiledkü:: arban küčütü-yin xutuq ötör olxu boltuyai: ...*
6. *Mila burxan Xormustu yeke tenggeriyin z[a]rliq orošiboi*, 13 хуудас
7. Гарчиггүй [Агуулга нь: Čilayun-u bičig], 6 хуудас. Өмнөх ирээдүйг эш үзүүлсэн бошгын товчилсон хувилбар.  
Эхлэл: *N[a]mo guru abaraltan dedü yurban erdeni-dü mürgemüi: na zha ja taya ku-du nige gertei čulun buijai ireqse-ece yar[a]qsan nomin z[a]rliq egüni debter z[a]r tarxabal buyun yeke bolmui:: ...*
8. *xutuqtu doqšin šiyike neretü sudur orošibai*, 4 хуудас
9. [Гарчиггүй]. Эхлэл: *ese bögösü beyed yadyal mon:: tegebel kümün bükü-dü ta-bin jili ayuul-du ülü ucir[a]mtui*. Өврийн ном болох зориулалтай тарни агуулсан ном, 6 нүүр.

### **Үл мэдэгдэх бичээч нарын босгосон хуучин ном**

1. *xutuqtu biligiin činadu kürügsen tasuluqči ucir kemekü yeke kölgöni sudur orošiboi*, гар аргаар үйлдвэрлэсэн орос цаасан дээр босгосон 35 хуудас бүхий судар, 1 хуудас нь С. Наадгайн гараар бичсэн.
2. *xutuqtu sayin yabudaliyin irööliyin xān orošiboi*: Механикжуулсан үйлдвэрийн орос цаас, 17 хуудас.
3. *buuriyin sang: arban zügiyin xarangyui arilyaqči: möriyin sang orošibo::* гар аргаар үйлдвэрлэсэн орос цаасан дээр бичсэн 7 хуудас, 1 хуудас нь С. Наадгайн гараар бичсэн.

1v-3r: [buuriyin sang:]

3r-5v: *xutuq-tu arban zügi-yin xarangyui büküni teyin arilyaqči kemekü yeke kölgöni sudur*

5v-7v: [möriyin sang orošibo] Эхлэл: *namo buddhā-ya: namo dharmā-ya namā sangghā-ya: yurban kürdüyigi sedkiqsen-yēr tögünčilen medeqči tedeni dörbüñ tantariqsani [!] dotorōn orouluqsan amitan bügüde-dü endöürel ügei ünen möriyigi üzüülüqči xamugi medeqči nomiyin boqdo-du zalbarimui:: ...*

[8r]: Наадгайн бичсэн хураангуй щагаан толгой

4. *xara ama kele xariuluqči sudur orošiboi*: Зая Бандидагийн орчуулга (*raŋdida Rab 'byam 'corji*). Гар аргаар үйлдвэрлэсэн орос цаас, 8 хуудас.
5. Тариачийн Нанзадын (1919/20 - ?) бичсэн тод үсгийн цагаан толгой (Орчин үеийн сурх бичиг маягаар ардын засгийн үед зохиосон. *Oron büküni proletar nar neqdeqtun, Arki, šašin xoyor xortoi* гэх мэтийн дасгал өгүүлбэртэй.).

## Дүгнэлт

Алтай Urianchayn долоон хошууны газар нутагт тод үсгийн дурсгал Или Тэксээ зэрэг газруудтай харьцуулвал харьцангуй цөөн боловч уг байдалд 20-р зууны улсын хил давсан нүүдэл суудал, дайн дээрмийн үймээн самуун, шилжилтийн хөдөлгөөн, шашны хэлмэгдэл зэрэг түүхийн олон шалтгаан нөлөөлсөн байна. Өнөөдөр Баян-Өлгий, Ховд аймгийн хөдөөний Алтай Urianchaychuudyн дунд тод үсгийн уламжлалт мэдлэг үлэмж ховор болсон ч 20-р зууны үед Алтай Urianchaychuudyн дунд тод үсэг мэддэг, үр хүүхдэдээ зааж сургахыг хичээдэг, шашны ном өөрийн гэр бүр болон нутгийнхаа сүсэгтэнд нээж уншдаг, шинэ судар хуулбарлан босгодог орон нутгийн түүхийн нэр хүндтэй хүмүүс байсан гэж аман түүх гэрчилнэ. Тэдний дотроос гурван жишээг энэ өгүүлэлд танилцуулахыг зорив. 20-р зууны үед шашингүй үзлийг чухалчилсан нийгмийн үед шашны ном, үйл ажиллагаа, шашин шүтлэгийн эрдэм мэдлэгийг залуу үедээ залгамжлуулахыг хориглосон цагт тод үсгийн уламжлалт хэрэглээ Алтай Urianchaychuudyн дунд үндсэндээ мөхөв. Гэхдээ тод номыг унших, хэрэглэх сонирхол хөдөөний Алтай Urianchaychuudyн дунд амьд байгаа тул боловсролыг хязгаарладаггүй өнөөгийн нийгэмд тод бичгийн мэдлэг сэргээн нэвтрүүлэх боломж нээлттэй буй.

## НОМ ЗҮЙ


- Erdemtü Mingyad. 2014. *Yirtinčü-yin kijayar-taki saran-u gerel*. Qayilar, Öbür mongol-un soyul-un keblel-ün qoriy-a.
- Luvsandordž, Džügderhn – Vacek, Jaroslav. 1990. *Otažky a odpovědi*. Praha: SPN.
- Vacek, Jaroslav. 1980. Za vypravěči do Altaje. *Nové Orient*. 35(7), s. 206–208.
- МУЗСЭХ = Монголын угсаатны зүйн судалгааны эх хэрэглэгдэхүүн (1988–1989) – *Field reports in Mongolian ethnology (1988–1989)*. X. Ulaanbaatar: Institute of History, Mongolian Academy of Sciences – Inner Asia Studies Unit, University of Cambridge, 2011.
- Пунцагдорж, Б. 1990. *Алтай Urianchayn аман зохиолын цоморлиг*. Өлгий.
- Цолоо, Ж. - Мөнхцэцэг, А. 2008. *Urianchayn өв соёл*. Улаанбаатар, МУ ШУА, Хэл зохиолын хүрээлэн.
- Ondřej Srba (Department of Linguistics and Baltic Languages, Faculty of Arts, Masaryk University)



Д. Муужаагийн зураг (Р.Чадраабал хангав)



1978 онд С. Наадгай Ж. Лувсандоржстай ярилцаж байгаа зураг  
(Mongolo-Tibetica Pragensia '09, Volume 2, No. 2, Special Commemorative  
Issue in Honour of Assoc. prof. J. Lubsangdorji on his 70th birthday, хавсралт зураг 5)



С. Наадгайн хэрэглэж байсан модон үзэг болон бэхийн сав



С. Наадгайн өөрийн бичсэн гар бичмэлээс

## ГАРЧИГ

Өмнөх үг .....	3
Хурлын урилга .....	5
Гэрэл зурагийн сурвалжлага .....	9
<b>Б.Түвшинтөгс.</b> Төвд бичгийг тод үсгээр галиглаж ирсэн уламжлал .....	15
<b>Ондрей Срба / Ondřej Srba</b> Монгол улсын Алтай Урианхайчуудын Тод үсгийн хэрэглээ (Аман түүхийн судалгаа) .....	24
<b>Б. Батмөнх.</b> Ховд аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй тод судрууд .....	35
<b>Д.Дүгэр, Б.Цэнд-Аюуш.</b> Увс аймгийн музейн сан хөмрөг дэх тод үсгийн дурсгалууд .....	43
<b>Бирталан Агнэш, Ракоши Атила.</b> Oirat Manuscripts and Xylographs Kept in the Oriental Collection of the Hungarian Academy of Sciences .....	55
<b>Д.Таяа.</b> Ойрад Монголын бичиг соёлын түүхийн асуудалд .....	59
<b>О.Самбуудорж.</b> Тод үсгийн эгшиг үсэг .....	66
<b>Х.Бямбажав.</b> Зая бандида огторгуйн далайн орчуулгыг төрөл зүйлээр ангилах .....	76
<b>Г.Ядамжав.</b> Зая бандида Намхайжамц хутагтын орчуулсан, тод үсгийн Найман мянгат буюу Жаддомба судрын тухай.....	87
<b>Л.Алтанзаяа.</b> Зая бандида Намхайжамцын орчуулсан нэгэн судрын тухай.....	109
<b>Б.Нацагдорж.</b> Зүүнгарын Ноён хамба Лувсанпунцагийн намтар <i>Их хамба очир баригч Лувсанпунцаг Балсамбуугийн туужж</i> залбирал сузэгтнийг эдгээх эм хэмээх оришив зохиолын тухай .....	114
<b>На.Сүхбаатар.</b> “Дөрвөн ойрад монголыг дарсан тууж” сурвалжийн тод үсгийн эхүүд.....	147
<b>Ц.Өнөрбаян.</b> “Тодорхой номын үсэг” судлалд тод мөртэй эрдэмтэн .....	161
<b>Н.Наранжаргал.</b> Халимагууд тод бичгийг хэрэглэж ирсэн түүхийн асуудалд .....	166
<b>А.Батсуурь.</b> Тод үсгийн зөв бичихүйд гарсан нэгэн өөрчлөлтийн тухай.....	191